Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2022.02.21

## Олон улсын хөрөнгийн зах зээл

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2022 он 02 сарын 21

**ТОВЧ**

- Өнгөрсөн 7 хоногт ОХУ цэргийн анги нэгтгэлээ хоёр улсын хилийн бүсээс эргүүлэн татсан гэж зарласан ч НАТО-гийн зүгээс цэргийн тоо нэмэгдсэн нь дайн эхлэх магадлалтай хэмээн онцлоод байна. Энэ нь олон улсын индексүүдийг унахад хүргэлээ.
- АНУ-ын худалдааны салбар 3.8 хувь өссөн нь шинжээчдийн таамаглалыг эвдлээ.
- Индексүүдийн хөдөлгөөн тодорхой бус үед үнэ цэнийн болон хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулах боломжтой юм.
- БНХАУ нь мөнгөний зөөлөн бодлого баримтлахаа зарласан бөгөөд Сангийн сайд нь татварыг бууруулж, мөнгөний нийлүүлэлтийг нэмнэ гэж мэдэгдсэн. Тиймээс энэ онд БНХАУ-н индексүүд өсөхөөр хүлээгдэж байна. Өнгөрсөн 7 сард Диди компани IPO хийснээс хойш анх удаа олон улсын эмнэлгийн тоног төхөөрөмжийн Мэхиа компани олон нийтэд нээлттэй боллоо.

| | |
|---|---|
| Dow Jones | 34,079 |
| S&P 500 | 4,348 |
| Nasdaq | 13,548 |
| DAX | 15,042 |
| FTSE | 7,513 |
| S&P/ASX | 7,212 |
| HANG SENG | 24,122 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Улирал | Хагас жил | Жил | 5 жил |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | -0.68% | -1.77% | -0.54% | -6.85% | -5.00% | -3.56% | 8.11% | 63.67% |
| S&P 500 | -0.72% | -1.44% | -1.12% | -9.33% | -7.56% | -2.92% | 12.19% | 83.70% |
| Nasdaq | -1.23% | -1.60% | -1.60% | -14.43% | -15.29% | -9.33% | 0.11% | 131.78% |

2022 оны 02 сарын 21-ний 10:00

**DJIA 34,694** дээр нээгдэж **34,079** дээр хаагдлаа. **SP500** индексийн хувьд **1.44%** хувь унасан долоо хоног өнгөрлөө.

### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Улирал | Хагас жил | Жил | 5 жил |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| DAX | -1.47% | 0.61% | -3.60% | -6.11% | -7.27% | -5.11% | 7.83% | 27.44% |
| FTSE 100 | 0.32% | -1.92% | 0.26% | 0.11% | 3.55% | 5.69% | 13.63% | 3.73% |

2022 оны 02 сарын 21-ний 10:00

**FTSE 100** (Лондонгийн биржийн топ-100 компани) индекс **1.92** хувийн уналттай байсан бол **DAX** (Франкфуртийн биржийн топ 30 компани) **0.61** хувийн өсөлт мөн үзүүлжээ.

### Азийн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Улирал | Хагас жил | Жил | 5 жил |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 0.033% | -0.34% | 0.61% | -4.88% | -2.20% | -3.61% | 6.47% | 25.79% |
| Hang Seng | -0.90% | -2.49% | -3.43% | 3.59% | -4.78% | -3.98% | -20.48% | 0.60% |

2022 оны 02 сарын 21-ний 10:00

**S&P/ASX200** (Австралийн биржийн топ 200 компани) индекс хувь **0.34** хувь өссөн бол **Hang Seng** (ХонКонгийн биржийн индекс) **2.49** хувь уналт үзүүлсэн байв.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2022 оны 02 сарын 21

**АНУ-ын хөрөнгийн зах зээл**

- Өнгөрсөн 7 хоногт ОХУ-ын зүгээс Украйны хилээс цэргээ татсан хэмээн мэдэгдсэн нь хурцадмал байдлыг намжаасан. Харин Натогийн зүгээс ОХУ цэргээ эргүүлэн татаагүйгээр барахгүй хэдэн мянгаар нэмэгдсэн, гал нээх магадлалтай байгаа учраас НАТО болон Европын холбоо хариу цохилт өгөхөд бэлэн гэж мэдэгдлээ. Энэ нь хөрөнгийн зах зээлийг 2-4 хувиар унахад хүргэлээ. Хэдийгээр дэлхийн эдийн засаг бүхэлдээ сайжирч байгаа ч хөрөнгийн зах зээлд дайн эхлэх вий гэсэн болгоомжлол хүчтэй нөлөөлж байна.

Нөгөө талд дайны үед үнэд ордог бүтээгдэхүүн болох газрын тосны үнэ 90 ам.долларын босгыг давлаа. ОХУ нь дэлхийн газрын тосны нийт хэрэглээний 40 хувийг хангадаг бөгөөд Европ тивийн гол тоглогч билээ.

- Он гарснаас хойш 22 хувийн өндөр өгөөж өгөх цорын ганц салбар байгаа нь эрчим хүчний салбар бол санхүү, үл хөдлөх хөрөнгө зэрэг бусад салбарууд уналттай байна.

- 2022.01 сард АНУ-ын худалднааны салбар 3.8 хувиар өсөж хүлээлтийн таамаглалыг 2 дахин нугаллаа. Шинжээчид омикроны тархалтын үед худалдан авалт зогсонги байдалд орно гэж тооцож байсан ч тавилга, автомашин, онлайн худалдааны салбар өсөв. Ирэх сарын 4-нд ажлын байр эрхлэлтийн мэдээ, 10-нд инфляцын мэдээлэл гарах юм.

**Одоогийн нөхцөл байдалд сонголт хийхэд тохирох багц**

- **Үнэ цэнийн болон циклийн хөрөнгө оруулалт:** Хавар, зуны улиралд эдийн засаг сэргэж, хүү өсөхөөр байгаа энэ үед циклийн хөрөнгө оруулалт оновчтой. Үүнд санхүүгийн салбар, үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбар орно.
- **Хөгжиж буй зах зээлийн хөрөнгө оруулалт:** Он гарснаас хойш цорын ганц өсөлттэй байгаа салбар нь хөгжиж буй зах зээл байна. Тус зах зээлд 2021 оныг хүртэл үнэ ашгийн харьцаа хямд арилжаагдсан бөгөөд 10 жилдээ үнэд ордог циклтэй.

График : Индексүүдийн өгөөж (оны эхнээс)




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

2022 оны 02 сарын 21

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.